

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Авлигын эсрэг хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл нь 2 зүйлтэй. 1 дүгээр зүйлээр Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээдийн хувь хүний орлогын албан татвар төлөлтийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байхаар хуулийн зохицуулалт нэмэлтээр оруулахаар төсөлд тусгасан. 2 дугаар зүйлээр хууль хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацааг заахаар тусгасан.

Авлигын эсрэг хууль 2006 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн өдрөөс хойш хэрэгжээд 20 орчим жил болох гэж байна. Энэ хугацаанд нийтийн албан тушаалтны хувь хүнийх нь хувьд хөрөнгө, орлого нь олон нийтэд нээлттэй болсон. Энэ нь авлигатай тэмцэхэд чухал ач холбогдолтой болсон.

Монгол Улс нэгэнт өмчийн бүх хэлбэрийг ялангуяа хувийн өмчийг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрч баталгаажуулсан тул иргэн ялангуяа нийтийн албан тушаалтан ямар хэмжээний хөрөнгөтэй байхаас илүүтэй тухайн хөрөнгийг олж авахдаа шударгаар буюу татвар төлсөн эсэх нь хууль зүйн онцгой ач холбогдолтой гэж үзсэн.

Хэрэв татвар төлөхгүйгээр орлого хөрөнгийг олж авсан бол шударга бусаар олж авсан гэж үзэх нэг хууль зүйн үндэслэл болох юм. Тиймээс нийтийн албан тушаалтны хувь хүний орлогын албан татвар төлөлтийн талаарх мэдээллийн нийтэд ил тод байлгах хууль зүйн шаардлагатай гэж үзэн Авлигын эсрэг хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл санаачилсан.

Аливаа этгээд шударгаар хөрөнгө, орлого олсон тохиолдолд тухай улсын хууль тогтоомжид заасны дагуу татвар төлдөг, эсхүл хууль тогтоомжид заасны дагуу татвараас чөлөөлөгддөг. Энэ нь дэлхийн нийтээр хүлээн зөвшөөрсөн нийтлэг зарчим, хэм хэмжээ юм. Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:... 3/хуулиар ногдуулсан албан татвар төлөх...” гэж заасан болно.

ХУУЛИЙН ТӨСӨЛ САНААЧЛАГЧ